



БАТЛАВ
ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Н.ХОНГОРЗУЛ

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМ, 4-Р БАГ 154-Р БАЙРНЫ ЗҮҮН ТАЛААР
ТӨВ ЗАМААС ТӨМӨР ЗАМЫН НҮХЭН ГАРЦ ХҮРТЛЭХ 0.42КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ
АВТО ЗАМЫН БАРИЛГЫН АЖИЛ**

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Сайншанд сум

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Сайншанд сум, 4-р баг 154-р байрны зүүн талаар төв замаас төмөр замын нүхэн гарц хүртлэх 0.42км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, нормын дагуу хийх ба дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

1. Ажил гүйцэтгэх хугацааны график (хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо)-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.
2. Зам, замын байгууламжийн ажлыг зам, замын байгууламжийн норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.
3. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.
4. Ажлыг техникийн ерөнхий шаардлагын дагуу дулааны улиралд гүйцэтгэнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Авто зам барих, Засварлах тусгай зөвшөөрөлтэй байх.
2. Зам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалтыг ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр төвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
3. Гэрээнд тусгагдсан ажил бүрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу гүйцэтгэнэ.
4. Авто замын барилга угсралтын ажлыг авто зам барих ажлын технологийн дарааллын дагуу гүйцэтгэнэ.
5. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.
Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.
6. Зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг, самбар байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

7. Барилга угсралтын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах.

8. Дүүргэгч материалын шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори, болон талбайн туршилт шинжилгээг техникийн шаардлагын дагуу хийж ил далд ажлын актад хавсаргах.

9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

10. Гүйцэтгэгч нь барилгын ажлыг ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, салбарын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, салбарын хяналтын улсын байцаагч өөрийн эрхийн дагуу барилгын ажилд хугацаатай албан даалгавар өгөх, торгууль тавих, тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Тендерийн материалд тавигдах шаардлага:

1. Төсвийн тооцоог "Авто замын барилгын ажлын жишиг норм" БНБД 81-25-07, Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн жишиг норм БНБД 81-26-08 суурь нормууд болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн 256 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНБД 81-013-2019-ыг ашиглан хийж гүйцэтгэнэ.

2. Ажилчдын тарифт цалинг "Зам, тээврийн хөгжлийн сайд"-ын 2019 оны 256 дугаар тушаалаар батлагдсаны дагуу ажилчдын үндсэн цалин, нэмэгдэл цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчдын цалин, нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн нийлбэрээс 15.1%-иар бодож төсөвт тусгах, Авто тээврийн зардлыг "Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ"-ийн дагуу тус тус тооцно.

3. Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дүгээр зүйлд заасны дагуу ажил олгогч (компани)-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер, техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11.7%-иар Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу "Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал"-ын шимтгэлийн хувь хэмжээг 2.8%-иар нийт 14.5%-иар тооцно.

4. ЗТАЖ-ын сайдын 2007 оны 187 дугаар тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63.5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71.8%-иар тооцно

5. Захиалагчийн хяналтын зардлыг төсвийн 2%, магадалшгүй ажлын зардлыг шууд зардлын дүнгээс 2%, нэмэгдсэн өртгийн албан татварыг "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтын дагуу барилга угсралтын ажлын зардлын дүнгээс 10%-иар тооцно.

6. ХАБЭА-н үйл ажиллагааны зардлыг шууд зардлын дүнгээс 2.5%-иар тооцно, энэ зардал нь "Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм"-ийн дагуу замын барилгын ажлын туршид хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал юм.

7. Норм, нормативын санг 0.4%-иар тооцно.

8. Үнийн тарифыг ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

9. Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын мэргэшсэн инженертэй байх.

Ажлын тоо хэмжээ

ТҮР БАРИЛГА БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-01-03	Ажилтнуудын зөврийн сууц байрлуулах	1 ш	2.0
2	25-01-05	Гал тогооны зөврийн байр байрлуулах	1 ш	1.0
3	25-01-12	Оффисын зөврийн байр байрлуулах	1 ш	1.0
4	25-01-13	Харуулын зөврийн байр байрлуулах	1 ш	1.0
5	25-01-24	Зөврийн био 00 (нойл) байрлуулах	1 сар	0.8

ЗАМЫН ЧИГ СЭРГЭЭХ, ГАДАСЛАХ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-02-02	Замын чиг сэргээх (GPS)	1 км	0.42

МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-03-01	Хөрсний шинжилгээ	1 удаа	2.0
2	25-03-03	Элсний шинжилгээ	1 удаа	1.0
3	25-03-05	Цементийн шинжилгээ хийх	1 удаа	2.0
4	25-03-07	Битумын шинжилгээ хийх	1 удаа	2.0
5	25-03-08	Асфальтбетоны орц тогтоох	1 удаа	2.0

ЗАМЫН ТРАСС, ТАЛБAYН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-04-02	Экскаватороор ургамлын үе хуулах	1 м3	1,343.95
2	25-04-04	Далангийн ул хөрс тэгшлэх, нягтруулах	1 м2	6,719.75
3	26-05-22	Замын хуучин хашлагыг механизмаар хуулж зайлуулах	1 м	50.0
4	26-05-24	Яваг хүний замын хуучин хавтанг хуулж зайлуулах	1 м2	63.93
5	26-10-25	Цементбетон хучилт молотоктой экскаватороор эадаж хуулж ачих	1 м3	53.3

ЗАМЫН ДАЛАН, УХМАЛЫН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-07-02	Экскаватораар ухмал байгуулах	1 м3	1,126.45
2	25-07-05	Шороон ордоос зөвөөр далан байгуулах	1 м3	515.0
3	25-07-12	Тохиромжгүй материал ухаж ачиж, зайлуулах (экскаватороор)	1 м3	750.96

ЗАМЫН СУУРИЙН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-07-08	Хөдөлгөөс хамгаалах үе байгуулах	1 м3	2,082.8
2	25-08-04	Буталсан чулуун хольцоор суурь байгуулах (автогрейдерээр)	1 м3	1,395.6

ЗАМЫН ХАШЛАГА БАЙРЛУУЛАХ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-09-02	Замын хашлага байрлуулах (1.0 x 0.3 x 0.18 м)	1 м	923.0

ЗАМЫН ХУЧИЛТЫН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-10-01	Шингэн цацлага хийх (Prime coat)	1 м2	3,880.66
2	25-10-02	Шингэн түрхлэг хийх (Task coat)	1 м2	3,880.66
3	25-10-04	Халуун асфальтбетон хольцоор суурь үе байгуулах	1 м3	155.23
4	25-10-05	Халуун асфальтбетон хольцоор өнгө үе байгуулах	1 м3	116.42

ЗАМЫН ХАЙРГАН ХӨВӨӨ БАЙГУУЛАХ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-11-01	Хайрган хөвөө механизмаар байгуулах (Хучлага хийсний дараах асгамал хөвөө)	1 м3	194.74

ДУГУЙН ЗАМЫН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-13-02	Дугуйн замын суурь буталсан чулуун хольцоор байгуулах	1 м3	272.66
2	25-13-05	Дугуйн замын хашлага байрлуулах	1 м	756.0
3	25-13-07	Дугуйн замын хучлага асфальтбетон хольцоор дэвсгэгээр байгуулах	1 м3	36.35

ЯВГАН ЗАМЫН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-13-05	Явган замын хашлага байрлуулах	1 м	756.0
2	25-13-01	Явган замын суурь зохист найрлага бүхий элс хайрган хольцоор байгуулах	1 м3	90.85
3	25-13-09	Явган хүний замын хучлага өнгөт хавтангаар байгуулах	1 м2	908.5

ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-14-03	Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар термопластик будгаар хийх	1 м2	131.1

ЗАМЫН ТӨНОГЛОЛЫН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-15-01	Замын тэмдэг суурилуулах	1 ш	11.0
2	25-15-03	Дохионы төмөрбетон шон суулгах	1 ш	4.0

ЗАМЫН ТОХИЖИЛТЫН АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-16-03	Зүлэгжүүлэх	1 м2	661.1
2	25-16-06	Хөлийн сав байрлуулах	1 ш	2.0
3	25-16-07	Сандал байрлуулах	1 ш	4.0

ХОГ, ХАЯГДАЛ ЦЭВЭРЛЭХ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-19-01	Асфальтбетон хучлага хийх үеийн хог цэвэрлэх	1 м3	30.0
2	25-19-02	Зам ашиглалтад өгөх үеийн хог цэвэрлэх	1 км	0.42

ХОГ, ХАЯГДАЛ ЦЭВЭРЛЭХ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
3	25-19-03	Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад үүсэх ахуйн хог хаягдлыг зөвшөөрөгдсөн газарт зайлуулах	1 тн	2.0

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ УЛСЫН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-20-01	Авто зам, замын байгууламжийн гүйцэтгэлийн зураг боловсруулах	1 км	0.42
2	25-20-02	Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах	1 км	0.42

БУСАД АЖИЛ

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	25-22-07	Хурд сааруулагч байгуулах (Асфальтбетон хольцоор)	1 м3	1.8
2	25-22-12	Замын гадаргуулийн ус зайлуулах сувгийн тэвш байрлуулах (УЗС-1-1) 500x300x180	1 м	20.0
3	25-22-17	Цахилгааны кабель сүвэгчлэх ган хоолой байрлуулах ф150мм	1 м	41.0
4	25-22-01	Худаг өндөрлөх	1 ш	4.0
5	26-06-16	Модон шон өндөрлөх	1 м	10.0

ИНЖЕНЕРИЙН ШУГАМ ХҮЧИТГЭХ АЖИЛ


№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	28-16-01	Ухмал байгуулах	1 м3	146.2
2	28-16-02	Ул суурь нягтруулах	1 м2	172.0
3	28-04-09	Буталсан чулуун суурь гараар байгуулах	1 м3	35.2
4	25-22-18	Хүчитгэсэн тэвш байрлуулах П-7	1 м	86.0
5	28-16-17	Буцаан дүүргэлт хийх	1 м3	63.2

ГАН ХООЛОЙН БАРИЛГА - D600 И БАЙРЛАЛД/

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ
1	28-16-01	Хоолойн суурийн ухмал	1 м3	20.7
2	28-16-02	Хоолойн ул суурь нягтруулах	1 м2	25.5
3	28-16-03	Хоолойн суурийг эхистэй ширхэгтэл бүхий элс хайргаар байгуулах	1 м3	6.25
4	28-16-07	Цементбетон суурь байгуулах	1 м3	5.1
5	25-22-17	Ус зайлуулах ган хоолой байрлуулах Ф-0.6м	1 м	17.0
6	28-16-08	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах	1 м3	0.881
7	28-16-12	Түрхмэл ус тусгаарлагч хийх	1 м2	56.61
8	28-16-13	Далангийн хажуу налууугийн элс цементэн зуурмагтай чулуун бэхлэгээ хийх	1 м2	4.9
9	28-16-14	Хоолойн орох, гарах хэсгийн чулуун бэхлэгээ хийх	1 м3	2.4
10	28-16-17	Буцаан дүүргэлт хийх	1 м3	8.84
11	28-16-18	Урсгалын хэвгийг экскаватороор засах	1 м3	21.8

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА



/Ц.МӨНХЭРДЭНЭ/

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:



/И.БЯМБАЦЭЦЭГ/